



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ
ДЭЛҮҮН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/145

Рашаант

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг
зохион багуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 9 дүгээр зүйлийн 9.3, 9.4, 9.5, 9.6, 9.8.1, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын А/251 тоот тушаал, Аймгийн Засаг даргын А/621 тоот захирамжыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд сумын хэмжээний бүх үхэр сүргийг бүрэн хамруулан 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 06-ны хооронд 20 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.
2. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын ажлыг зохих журмын дагуу зохион багуулан дархлаажуулалтын ажилд технологийн хяналт тавьж, мэдээ тайланг аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлэхийг Мал эмнэлгийн тасаг / С.Саулеш/-д даалгасугай.
3. Дархлаажуулалтын ажлыг газар дээр нь зохион байгуулах, малчин болон мал бүхий иргэдэд зар хүргэх, тогтоосон хугацаанд товлосон газарт малаа бэлэн байлгах ажлыг тухайн багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.
4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч / У.Аялбек /-д үүрэг болгосугай.
5. Дархлаажуулалтын явцын мэдээг өдөр бүр Мал эмнэлгийн тасагт хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт даалгасугай.

ДАРГА



Б.СЕРИКБОЛ